



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 5 сарын 21 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийт 101,284,310.00 (нэг зуун нэг сая хоёр зуун наян дөрвөн мянга гурван зуун арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Уранчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт



АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Принтер (өнгөт)	2008.01.01	1	607,840	607,840	607,840	-
2	Принтер	2007.01.01	1	207,450	207,450	207,450	-
3	Принтер	2010.01.01	1	440,000	440,000	440,000	-
4	LCD дэлгэц	2011.07.01	2	875,000	1,750,000	1,750,000	-
5	Зөөврийн компьютер	2009.01.01	1	450,000	450,000	450,000	-
6	Компьютер	2005.08.20	10	920,000	9,200,000	9,200,000	-
7	Зөөврийн компьютер	2010.01.01	1	1,595,000	1,595,000	1,595,000	-
8	Цагийн бүртгэлийн программын техөөрөмж	2006.01.01	1	900,000	900,000	900,000	-
9	Принтер	2005.01.01	1	274,720	274,720	274,720	-
10	Шарах шүүгээ	2002.01.01	1	488,400	488,400	488,400	-
11	Угаалгын машин	2012.02.17	1	339,400	339,400	339,400	-
12	Цайны тогоо	1970.01.01	1	841,190	841,190	841,190	-
13	Хөргөгч	1999.01.01	2	497,480	994,960	994,960	-
14	Амьсгалын аппарат	2009.01.01	1	18,686,130	18,686,130	18,686,130	-
15	Компьютер	2013.06.29	4	623,700	2,494,800	2,494,800	-
16	Шээсний анализатор	2004.01.01	1	1,109,440	1,109,440	1,109,440	-
17	Биохими хуучин аппарат	2005.01.01	1	20,399,300	20,399,300	20,399,300	-
18	Автоклав (цэвэр)	2004.01.01	1	4,401,000	4,401,000	4,401,000	-
19	Хөргөгч/ минск	1999.01.01	1	376,090	376,090	376,090	-
20	Шилэн нүүртэй хөргөгч	2002.01.01	2	358,435	716,870	716,870	-

21	Радио долгионы эмчилгээний аппарат \том саарал\IPL	2009.01.01	1	10,000,000	10,000,000	10,000,000	-
22	Шивээс арилгагч лазер аппарат \дөрвөлжин цагаан\	2009.01.01	1	4,330,000	4,330,000	4,330,000	-
23	Уурын аппарат	2009.01.01	2	190,000	380,000	380,000	-
24	Массаж аппарат \new magic\	2006.01.01	1	4,884,000	4,884,000	4,884,000	-
25	Их биеий массажны аппаратMolly 2300-1	2010.01.01	1	6,200,000	6,200,000	6,200,000	-
26	Баллон	2009.01.01	1	532,500	532,500	532,500	-
27	Хувцасны саарал төмөр шкаф	2008.01.01	2	170,000	340,000	340,000	-
28	Эхо аппарат	1984.01.01	1	7,285,720	7,285,720	7,285,720	-
29	Шингэн NO2-шуршигч	2000.01.01	1	1,059,500	1,059,500	1059500	-
	Нийт дүн	-	46	89,042,295.00 (наян есөн сая дөчин хоёр мянга хоёр зуун ерэн таван)	101,284,310.00 (нэг зуун нэг сая хоёр зуун наян дөрвөн мянга гурван зуун арван)	101,284,310.00 (нэг зуун нэг сая хоёр зуун наян дөрвөн мянга гурван зуун арван)	-